ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ГУБ НИНЖИЙН ЛХАГВАДЭЛГЭРИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

| № | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | ЗОРИЛТОТ ТҮВШИН | Хэрэгжилт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцон эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийг буруулах чиглэлээр 19 газар, хороодоос хийж хэрэгжүүлсэн ажилд хяналт тавьж эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллах.<br>2. Хууль тогтоомжийн эрсдэлийн судалгаа хийх. | 1.Гаалийн ерөнхий газрын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, гаалийн байгууллагын эрсдэлийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:<br>Судалгааны зорилго, үндэслэл<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын олон улсын аргачлал (WCO Risk Management Compendium, ISO 31000) болон холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, сахилгын зөрчил, гомдол мэдээллийг дүгнэх албан хаагчдын хандлага, ажиллах нөхцөл, сэтгэл ханамжийг тодорхойлох, байгууллагын манлайлал, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд бодитой арга хэмжээ боловсруулан ажиллалаа.<br>1.1.Хууль тогтоомжийн эрсдэлийн судалгаа: Google Form ашиглан 9 асуулгатай судалгаа явуулж, 510 албан хаагч оролцсон. Тус судалгаанаас хууль тогтоомжийн мэдээллийг цаг хугацаанд нь авах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагч нарт сургалт зохион байгуулах, хууль тогтоомжид гарч буй эрсдэлийг | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | багасгахад анхаарч ажиллах талаар дүгнэлт гарсан.<br>Тайланг ЧХОУНБГГ, СэГГ, ДоГГ, УХШИГГ, ГсГГ, Улс Шивээхүрэн ГГ , Баян-Өлгий ГГ, Ховд ГГ, Бичигт ГГ, СшГГ Ханги дахь гаалийн газар, Говь Алтай, Завхан, Хөвсгөл дэх гаалийн хороонд хүргүүлсэн.<br>1.2. Хүний нөөцийн эрсдэлийн судалгаа: Google Form ашиглан 12 асуулгатай судалгаанд 468 албан хаагч оролцсон. Судалгааны тайланг ГЕГ-ын дарга болон Захиргааны удирдлагын газарт болон Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн. | |
| 2 | Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авах. | Хэрэгжилт, тоогоор /дотоод шалгалтын тоо, дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо, албан хаагчид салгын арга хэмжээ авсан тоо, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо/ | 1. Гаалийн байгууллагын албан хаагчдын сахилга, ёс зүйн зөрчилд хариуцлага тооцсон байна.<br>2. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг авсан байна.<br>3. Сахилга ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдыг сахилгын хороонд шилжүүлсэн байна. | 1. ХНХ-ийн 2025.03.20-ны өдрийн 01120/48 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн УБГГ-ын ЗА-ны ГУАБ М.Н нь 2025 оны 01 сарын 13-ны өдрөөс хойш өвчтэй гэх боловч эмнэлгийн ямар нэгэн баримтыг одоог хүртэл ирүүлээгүй байх тул ЗА-ны ГУАБ-ын орон тооны асуудлыг шийдвэрлэж өгнө үү гэх асуудалд М.Н-ээс тайлбар болон холбогдох баримт, материалыг авах, УБГГ-ын Захиргааны албанаас цагийн бүртгэл болон бусад холбогдох баримтыг албан бичгээр авах, М.Н-ийн эмчлүүлсэн гэх эмнэлгүүдээс лавлагаа авах гэх мэт холбогдох албаны шалгалтын ажиллагааг хийж гүйцэтгэн Сахилгын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр шилжүүлсэн ба М.Н нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2. СЭГГ-ын ГУАБ Ж нь иргэн Б.Долзодмаа, Б.Наранзул нарыг 2025.0.27-ны өдөр Алтанбулаг боомтоор орж ирэх үед нь биед нь халдсан мөн байнга хүнтэй зүй бусаар харьцдаг гэх гомдлыг хүлээн авч иргэн Б.Долзодмаагаас тайлбар авсан, СЭГГ-ын ГУАБ Э.Ж, ГУБ Б.Б, ГУАБ Б.Л, ГУБ М.Б нараас тайлбар авсан. ШШГЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шинжилгээний 2025.04.25-ны өдрийн 177 дугаартай шинжээчийг дүгнэлтийг авч хавсаргах, тухайн өдрийн хяналтын камерын бичлэгийг хуулбарлан авах зэрэг дотоод хяналт шалгалтын ажиллагааг явуулахад СЭГГ-ын ГУАБ Ж нь иргэн Б.Долзодмаагийн биед гэмтэл учруулсан болох нь тогтоогдохгүй харин харьцааны болон ёс зүйн алдаа гаргасан нь камерын бичлэг болон бусад баримтаар нотлогдож байх ба 2025 оны 04 дүгээр сарын 18-ны 01-5/1583 дугаартай чиглэл хүргүүлэх албан бичгийг хүргүүлсэн. Мөн тус өдөр иргэн Б.Долзодмаатай холбогдож хариу мэдэгдсэн болно.<br>3. Ховд Булган дахь гаалийн газрын удирдлагын зүгээс элдэв зүй бус үгээр доромжилсон тул гомдолтой байна гэх гомдлыг хүлээн авч хянан үзэхэд ёс зүйн зөрчлийн шинжтэй гомдол байх тул 2025.05.28-ны өдрийн 01-5/2261 дугаартай албан бичгээр Ховд аймгийн Булган дахь гаалийн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | газрын ёс зүйн дэд хороонд харьяаллын дагуу шилжүүлсэн. | |
| 3 | Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх. | Хэрэгжилт, тоогоор /дотоод шалгалтын тоо/ | Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон албан хаагчидтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэл шалгагдаж шийдвэрлэгдсэн байна. | 1. Алтанбулаг боомтоор 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр ОХУ-ын хилээр нэвтэрсэн 02-15 УАК улсын дугаартай "GREAT WALL" маркийн, саарал өнгийн тээврийн хэрэгслийн жолоочоос 38 ширхэг гар утас, 80 мянган юань хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэх гомдол мэдээлэлд тухайн өдөр үүрэг гүйцэтгэж байсан албан хаагч нарын буруутай үйлдэл байсан эсэхийг тогтоож, холбогдогч нараас тайлбар мэдүүлэг авч ирүүлэх чиглэлийг СЭГГ-т хүргүүлсэн ба СЭГГ-ын ГУАБ Б.Л, ГУБ О.О, ГУБ Ч.Ө нарын буруутай үйлдэл тогтоогдоогүй.<br>2. УХШИГГ-ын ГУАБ А.О нь 4-5 хоногийн өмнө DHL салбар дахь ажил дээрээ согтуу байсан гэх гомдол мэдээллийн дагуу УХШИГГ-ийн ГУАБ А.О, ГУАБ Б.Х, ГУБ Б.Т, ГУБ Н.Б нараас тайлбар авах, ХУД-ийн Цагдаагийн 2-р хэлтсээс лавлагаа авах болон бусад холбогдох хяналт шалгалтын ажиллагааг явуулахад УХШИГГ-ын ГУБ А.О нь ажлын байран дээр архи болон согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн болох нь тогтоогдохгүй байх тул 2025.04.18-ны өдрийн 15 цаг 31 минутад албаны 350048 дугаарын утаснаас гомдол гаргагч Д.Дамдиндоржийн 99112587 дугаарын | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | гар утасруу залгаж холбогдон гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх хариуг мэдэгдсэн болно. | |
| 4 | Гаалийн байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалт хийх, гарсан үр дүнгээр зөвлөмж өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Дотоод хяналт, шалгалтаар гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой зөрчил илрүүлж хариуцлага тооцуулах. | 1. Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын салбар лабораторийн шинжээч, гаалийн улсын байцаагч Б.М, ахлах шинжээч ГУАБ Э.Б нар нь "Энка глобал констракшн" ХХК-ийн 04-2111004-24-I30936 дугаартай мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн бараанд Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын Салбар лабораторийн 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн №0424002604 дугаартай магадлан шинжилгээгээр БТКУС-ийн ангиллын 3907300 кодоор CONBEXTRA EP10 гэж мэдүүлснийг БТКУС-ийн ангиллын 32149000 кодоор CONBEXTRA EP10 /base, hardener/ гэж шинжлэн "Шинжилгээний дүн болон дагалдах бичиг баримтыг үндэслэн тус компанийн импортолж буй бараа нь эпоксидын давирхай болон изофрондиаминд суурилагдсан хананы хагарал, цууралтыг нөхөх, бэхжүүлэх зориулалттай бүтээгдэхүүн байна" гэсэн дүгнэлтийг гаргаж кодыг өөрчилсөн. Улсын хилээр нэвтрүүлэхэд БОАЖЯ-ны химийн хорт болон аюултай бодисыг импортлох тусгай зөвшөөрөлтэй барааг тусгай зөвшөөрөлгүй болгосон дүгнэлт гаргасан. Тус аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрөлгүй байсан. Удирдлагад танилцуулж ГЕГ-ын сахилгын хороонд шилжүүлсэн ба ГЕГ-ын даргын | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2025.03.14-ний Б/143 дугаартай тушаалаар Э.Б-д зэрэг дэвийг 1 жилийн хугацаанд 1 шатлал бууруулах, Б/147 Б.М-т сануулах сахилгын шийтгэл ногдуулсан.<br>2. ГЕГ-ын Сахилгын хорооны даргын чиглэлийн дагуу 2025.03.11-ний өдрийн 01-5/972 дугаартай албан бичгээр ЧХОУНБГГ-т ГУАБ Н.Б-ийн ажил тасалсан үйлдэлд "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.5.7, Гаалийн тухай хуулийн 284 дүгээр зүйлийн 284.1.1, 284.1.2-т зааснаар арга хэмжээ авч холбогдох материалыг ирүүлэх, цаашид эрэлч нохой хариуцсан үндсэн чиг үүргийн ажлыг нь хийлгэх чиглэлийг хүргүүлсэн.<br>3. СЭГГ-т 2025 оны 04 дүгээр сарын 18-ны 01-5/1583 дугаартай чиглэл хүргүүлэх албан бичгийг хүргүүлсэн.<br>4. ХНХ-ийн 01120/112 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн шагналд нэр дэвшүүлсэн 127 албан хаагч, ажилчдын сахилга, ёс зүйн зөрчилтэй эсэх, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа эсэхийг тус хэлтсийн зөрчлийн мэдээллийн сангаас шүүж үзэхэд Бүрдүүлэлтийн цахим төвийн гаалийн улсын байцаагч М.Х-д ГЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Б/860 дугаартай тушаалаар сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байх тул 2025.05.28-ны өдрийн 617 дугаартай дотоод зурвасаар хариуг хүргүүлсэн болно. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. “Гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын төслийг Хуулийн хэлтэстэй хамтран Захиргааны Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах. | 1. Дотоод хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг шинэчилсэн. Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг 2025.04.01-ний өдөр Гаалийн ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2025.04.11-ний А/138 дугаар тушаалаар батлуулсан. Шинэчлэгдсэн журам нь гаалийн салбарын дотоод хяналтыг илүү үр дүнтэй, уялдаа холбоотой, хариуцлага хүлээлгэх тогтолцоотой болгоход чиглэгдсэн. | |
| 6 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажиллах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Чиг үүргийн хүрээнд Монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайлагнаж ажилласан байна. | 1. ХНХ-ийн 378 дугаартай дотоод зурвасын дагуу Ч.Дөлгөөнд холбогдох асуудалд албаны шалгалт хийсэн тухай танилцуулгыг хуулбарлан, нотлох баримтын шаардлага хангуулан дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>2. ХХ-ийн 108 дугаартай дотоод зурвасын дагуу 2025.03.17-ны өдрийн 273 дугаартай дотоод зурвасаар Ч.Дөлгөөнд холбогдох асуудалд албаны шалгалт хийсэн материалыг хуулбарлан, нотлох баримтын шаардлага хангуулан хүргүүлсэн. /Нийслэлийн захиргааны хэргийн шүүхээс ХХ-т албан бичиг ирүүлсэн./ | |
| 7 | Үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн | 1. ХНХ-ийн 01 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн “Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх ажлын | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | биелүүлж ажилласан байна.<br>2. ГЕГ-ын ЗББНДБ болон ХГГХ-дод хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна. | төлөвлөгөөнд тус хэлтсийн зүгээс өгөх саналын талаар хариу дотоод зурвас хүргүүлсэн.<br>2. 2025.03.24-ний өдрийн 289 дугаартай дотоод зурвасаар Хяналт, бүрдүүлэлтийн газарт "Гаалийн хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих журам"-ын төсөлд санал хүргүүлсэн.<br>3. ХНХ-т Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газарт эм, биобэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчаар ажиллаж байсан Сүхбаатарын Уранцэцэг нь ажиллах хугацаандаа сахилгын шийтгэл хүлээж байсан эсэх талаарх мэдээллийг дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>4. Хүний нөөцийн хэлтсийн 01120/1 дугаартай дотоод зурвасын дагуу "Гаалийн байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөртэй танилцан ГЕГ-ын 2025 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>5. Сургалтын төвийн 01500/2 дугаартай дотоод зурвасын дагуу сургалтын төлөвлөгөөний төсвийг багасгаж гарган саналыг хүргүүлсэн.<br>6. ЗУГ-ын 01100/2 дугаартай дотоод зурвасын дагуу "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг албан хаагч нарт танилцуулсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 10 албан бичиг хүлээн авснаас 9 албан бичгийг шийдвэрлэж, 1 албан бичиг судалж байгаа төлөвт байна. Мөн дээрх хугацаанд 10 албан бичгийг гаалийн байгууллагын бүтцийн нэгж, харьяа газар, хороо болон бусад байгууллагад хүргүүлж ажилласан байна. | |
| 8 | Ажлын цаг ашиглалт. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Ажлын цаг ашиглалтыг өмнөх оны мөн үеэс бууруулаагүй байх. | Ажлын цагийг баримталж, цаг бүртгэлийн төхөөрөмжид өдөр тутам ажлын цагаа бүртгүүлэн ажиллаж байна. 2025 оны 01 дүгээр сарын 30, 31, 2025 оны 05 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд өвчний акттай байсан болно. 2025.04.21-ний өдрөөс 2025.05.26-ны өдөр ээлжийн амралтаа авсан болно. | |
| 9 | Гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн хэргийн мэдлэг зохих түвшинд дээшилсэн байна. /I-IV улирал/ | 1. Хэлтсийн албан хаагч нарын дунд 7 хоногт 1 удаа Монгол хэл бичгийн хичээл орж байгаа ба Монгол бичгийн чадвар дээшилсэн.<br>2. “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам” шинээр батлуулсантай холбогдуулан уг журмыг судалж түүнийгээ өдөр тутам үйл ажиллагаандаа ашиглаж, удирдлагаас заавар чиглэл аван мэдлэг чадвараа дээшлүүлэн ажиллаж байна. | |

ТАЙЛАН ГАРГАСАН: Н. Лхагвадэлгэр ........................................./ГУБ Н.ЛХАГВАДЭЛГЭР/

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НИНЖИЙН ЛХАГВАДЭЛГЭРИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Дотоод хяналт, шалгалт хийх. | 56 | 10 | 66 | |
| 2. | Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх. | 60 | 10 | 70 | |
| 3. | Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэх. | 60 | 10 | 70 | |
| 4. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт. | 56 | 10 | 66 | |
| 5. | Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, гадуур ажилласан, өвчтэй, чөлөөтэй тохиолдол бүрт СЕРП программаар тухай бүр илгээж ажиллах. | 56 | 10 | 66 | |
| 6. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт. | 51 | 10 | 61 | |
| 7. | Үүрэг даалгаврын биелэлт | 56 | 8 | 64 | |
| 8. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх | 56 | 8 | 64 | |
| “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд | | | | | |
| 1. | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | 60 | 10 | 70 | |
| 2. | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын | 56 | 10 | 66 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | |
| **Дундаж оноо:** | | | | 66 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх. | 85% | 11 | |
| **Дундаж оноо** | | | 11 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. Өргөдөл, гомдол шийдвэрлэлт | 6 | |
| **Дундаж оноо** | | 6 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 7 |
| **Дундаж оноо** | | 7 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *66* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *11* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *7* |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |

| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | 90% |
|---|---|

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс
*(албан тушаал)*

.................................. /Л.Очгэрэл/
*(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.10 ............................. *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн гаалийн улсын байцаагч
*(албан тушаал)*

Н. Лхагвадэлгэр ................................ /Н.Лхагвадэлгэр/
*(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.10 ....................... *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,
*(албан тушаал)*

................................ / Г.Энхтайван /
*(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.25 ....................... *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ГЕГ-ын хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч
*(албан тушаал)*

............................. / Ө.Тэгшээ /
*(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.25 ....................... *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ГЕГ-ын дарга
*(албан тушаал)*

................................ / Р.Отгонжаргал /
*(гарын үсэг)* *(албан хзаагчийн нэр)*

2025.06.25 ....................... *(огноо)*